

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ЧОЙБАЛСАН НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2022.08.08

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2022 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн “Дорнод аймаг дахь Чойбалсан нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 08/22 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны менежер Ө.Мөнгөнжигүүр, аудитор А.Мөнх-Эрдэнэ, СХОГ-ын нягтлан бодогч А.Баатархүү, ИНҮТ-ийн СЭЗТГ-ын нягтлан бодогч Ж.Нямдэлгэр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2022 оны 8 дугаар сарын 03-ны өдрөөс 2022 оны 8 дугаар сарын 05-ны өдрүүдэд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Дорнод аймаг дахь Чойбалсан нисэх буудлын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны төсвийн гүйцэтгэл, зарцуулалт, үр ашгийн байдал, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт, албан хэрэг хөтлөлтийн байдал, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, нисэх буудлын үйл ажиллагаатай холбоотой удирдах дээд байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн хэрэгжилт, албан даалгаврын биелэлт, гадны байгууллага, иргэнтэй хийсэн гэрээ хэлцэл, худалдан авалт, түүний эрх зүйн үндэслэл, хэрэгжилт, нэгжийн бүтэц орон тоо, цалин хөлсний тооцоолол, албан тушаалын тодорхойлолт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, цалин хөлсний бодолт, олголт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Ээлжийн ажилчдын илүү цагийн нэмэгдэл хөлсийг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгох байсныг хоёр дахин нэмэгдүүлж 1,169,088 төгрөгийг илүү олгосон байна.

Ажлын цагийн тооцоог боловсруулсан мэргэжилтэн цагийн тооцоог буруу гаргаж, Захиргаа, аж ахуйн хэсгийн хяналт сул байснаас цалингийн тооцоолол алдаатай хийгдэж ээлжийн амралт, цалин хөлс давхацсан байна.

Хавсран ажилласаны нэмэгдэл хөлсийг хавсран ажиллаагүй хугацаанд олгож ДАА-ны 2021 оны аудит шалгалтаар илэрсэн зөрчил давтагдсан.

Чойбалсан нисэх буудлын даргын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Б/02 дугаар “Удаан жилийн нэмэгдэл олгох тухай” тушаалаас түүвэрлэн нэмэгдэл олгох хугацааг шалгахад огноо зөрүүтэй, хувийн хэргийн баяжилт хангалтгүй, ажилласан жил хангалттай нотлогдохгүй байна.

Бараа материалын нягтлан бодох бүртгэлийн хяналт хангалтгүй, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн эд хариуцагчийн картын бүртгэл хөтлөөгүй, нягтлан бодох бүртгэлийн хяналт хангалтгүй байна.

Зорчигч үйлчилгээний хураамж болон үнэмлэх борлуулсны орлогод Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулаагүй, нэмэгдсэн өртгийн албан татварын нэгтгэл тайланд хасагдахгүй НӨАТ-ыг хасаж тооцон нэгтгүүлж тайлагнасан.

Хувь хүний орлогын албан татвар суутгаагүй, иргэний өмнөөс 96,000 төгрөгийн татварыг төлөхөөр тайлагнаж, холбогдох зардлыг өсгөсөн.

Бараа материал худалдан авахдаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасан “хасагдах зардлын шаарлага”-ыг хангаагүй буюу дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтгүй худалдан авалт хийсэн.



Цахилгааны зардлыг өсгөсөн, төлбөр төлсөн тухай бүрт авах авлагыг бүртгэдэггүй.

Ашиглагдаж буй автомашинуудын ашиглалт, шатахуун зарцуулалтын байдлыг шалгахад Галын Dong-Feng машин, Талбай цэвэрлэгээний Ко-829 /Камаз КПМ/ маркийн автомашинуудын “Авто тээврийн хэрэгслийн хувийн хэрэг”-ийн бүх автомашинуудын Эзэмшигчид хүлээлцсэн бүртгэлийг хөтлөөгүй, замын хуудас, шатахууны тооцоо бодсон баримтад автомашинуудын гүйлт, мото цагийг тулгаагүй байна.

Шатахуун худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Худалдан авах ажиллагааны журмыг хэрэглээгүй шууд худалдан авалт хийсэн. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэгдээгүй, худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн гэрчилгээтэй 1 ажилтан ажиллаж байгаа нь цаашид худалдан авах ажиллагааг хуулийн дагуу явуулах нөөц хангалтгүй байна.

Эхний хагас жилийн Шилэн дансны мэдээллийг шалгахад 2 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн. Мэдээллийн үнэн зөв байдлыг шалгахад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10. дахь заалтыг зөрчиж 2 гүйлгээний шийдвэрийн хуулбарыг хавсаргаагүй, мөн мэдээллийн зарим талбарыг буруу мэдээлдэг, төсвийн гүйцэтгэлийг мэдээлэхдээ цэг таслалыг алдаатай тавьж, ДАА-ны 2021 оны аудит шалгалтаар илэрсэн мэдээллийг буруу оруулсан зөрчил давтагдсан.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Дорнод аймаг дахь Чойбалсан нисэх буудалд 17 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА